



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 11 сарын 14 өдөр

Дугаар А/518

Улаанбаатар хот

Журам шинэчилэн батлах тухай

Засгийн газрын агетлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. "Техникийн комиссын ажиллах журам" нэгдүгээр, "Техникийн комиссын бүрэлдэхүүн"-ийг хоёрдугаар, "Техникийн тодорхойлолтын хуудас"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтийг ханган ажиллахыг нийт албан хаагчдад, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /М.Төрбат/-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын даргын 2015 оны А/121 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.МӨРӨН

000003469

Гадаадын иргэн, харьяатын
газрын даргын 2017 оны 116 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

ТЕХНИКИЙН КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг . Нийтлэл үндэслэл

1.1 Байгууллагын автомашины техникийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааг хангах, дүгнэлт гаргах үүрэг бүхий Техникийн комиссын үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2 Техникийн комисс нь Засгийн газрын 2015 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 184 дүгээр тогтоол, холбогдох эрх зүйн актыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

Хоёр. Техникийн комиссын эрх

2.1 Техникийн комисс дараах эрхтэй:

2.1.1 Эрх бүхий байгууллагаас баталсан автомашин ашиглалтын жишиг нормыг үндэслэн автомашины ашиглалтын нормыг тогтоох, хянах, өөрчлөх, хүчингүй болгох, автомашиныг хүлээн авах, бусдад шилжүүлэх, худалдах, засварлах, актлах талаар дүгнэлт гаргах, автомашины сэлбэг хэрэгслийг бэлтгэн нийлүүлэх, засварлахад хяналт тавих;

2.1.2 Улсын авто замын сүлжээг үндэслэн байгууллагын төв байрнаас орон нутагт хүрч ажиллах, орон нутаг дахь, нэгжийн байрнаас бүх боомт, цэгүүдийн зайг тогтоож баталгаажуулах ба үүнийг үндэслэн тухайн ажилд шаардагдах зардлын ерөнхий тооцоог гаргах;

2.1.3 Мэргэжлийн байгууллагын инженер, техникийн ажилтныг шаардлагатай тохиолдолд ажиллуулах;

Гурав. Техникийн комиссын ажиллах журам

3.1 Хангалт үйлчилгээний асуудал хариуцсан нэгжээс Техникийн комиссыг шаардлагатай тохиолдолд хуралдуулж, автомашины техникийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагаанд дотоод хяналт, үзлэгийг хийлгэнэ.

3.2 Техникийн комиссын дүгнэлтээр зайлшгүй засварлах буюу солих шаардлагатай эд ангийг автомашины сэлбэг хэрэгсэл нийлүүлдэг 2-3 аж ахуйн нэгж, иргэний үнийн болон чанарын баталгааны санал авч, Комиссын дарга, гишүүдийн оролцоотойгоор сонголт хийсний үндсэн дээр шаардлагатай сэлбэг хэрэгслийг бэлтгэн нийлүүлэх санал болгоно.

3.3 Автомашины эд ангийг солих, засварлах ажлыг тухайн автомашиныг эзэмшигч жолооч хариуцан гүйцэтгэх ба Төвд Хангалт үйлчилгээний асуудал хариуцсан нэгжийн зохион байгуулагч, автомеханикч, орон нутагт нэгжийн дарга хяналт тавина.

3.4 Жолооч бие даан засварлах боломжгүй засвар үйлчилгээг Техникийн комиссын дүгнэлт, саналыг үндэслэн засварын газраар гүйцэтгүүлж болно.

3.5 Байгууллагын хэрэгцээнд автомашин худалдаж буюу шилжүүлж авахад Техникийн комисс уг автомашины техникийн бүрэн бүтэн байдал, чанар, аюулгүй байдалд үзлэг шалгалт хийж, бүртгэж авна.

3.6 Байгууллагын хэрэгцээнд ашиглагдаж байсан автомашиныг холбогдох газрын шийдвэрээр бусдад шилжүүлэхэд Техникийн комисс дүгнэлт гаргана.


3.7 Байгууллагын автомашины гүйлтын норм дууссан, чанар, аюулгүй байдлын хувьд ашиглах боломжгүй болсон талаар Техникийн комиссын дүгнэлт гарган тухайн автомашиныг актлах, үнэ тогтоох, бусад асуудлыг холбогдох комисстой хамтран зохих журмын дагуу шийдвэрлэнэ.

3.8 Орон нутаг дахь нэгжийн автомашинд 1.000.000 / нэг сая /төгрөгөөс дээш өртөгтэй засвар үйлчилгээ хийх шаардлага гарсан тохиолдолд орон нутаг дахь техникийн комиссын шийдвэр, техникийн тодорхойлолтыг Төвд урьдчилан мэдэгдэж шийдвэрлүүлнэ.

.....

Гадаадын иргэн, харьяатын
газрын даргын 2017 оны 11518 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

ТЕХНИКИЙН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН



Төвд:

Комиссын дарга:

Хангалт, үйлчилгээний асуудал хариуцсан нэгжийн дарга

Гишүүд:

- Санхүүгийн асуудал хариуцсан нэгжийн нягтлан бодогч
- Хангалт, үйлчилгээний асуудал хариуцсан нэгжийн зохион байгуулагч
- Хангалт, үйлчилгээний асуудал хариуцсан нэгжийн автомеханикч
- Жолооч

Орон нутагт:


Комиссын дарга:

- Орон нутаг дахь нэгжийн дарга

Гишүүд:

- Орон нутаг дахь нэгжийн нягтлан бодогч
- Жолооч

Гадаадын иргэн, харьяатын
газрын даргын 2017 оны 11/5 дугаар
тушаалын гуравдугаар хавсралт



Техникийн тодорхойлолт

.....
Байгууллагын нэр:

20.... оны сарын өдөр

Техникийн нэр марк, улсын дугаар

.....
Гэмтлийн шалтгаан:

.....
.....
.....
.....
.....
.....

тул ажлын шаардлага хангахгүй болсоныг тодорхойлов.

Санал:

.....
.....

Удирдлагын шийдвэр:

.....
.....

Тодорхойлолт гаргасан:

Инженер: / /

Зөвшөөрсөн эзэмшигч: / /

.....
Эзэмшигчийн нэр